# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Хөвсгөл “АЗЗА”  ТӨХК -ийн 2023 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХӨА-2024/26/НА-СТА-ТЗШ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Хөвсгөл аймаг<br>2024 он | Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар<br>Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn<br>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр<br>Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn<br>Аудитор: С.Гансүх<br>Утас: 95908400 Цахим хаяг: gansukhsa@audit.gov.mn<br>“Бэйкир Тилли Далайван аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын захирал: Д.Мягмарсүрэн<br>Утас: 99030170, Цахим хаяг: dalaivan.et@gmail.com<br>“Бэйкир Тилли Далайван аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын аудитор: Б.Пүрэвсүрэн<br>Утас:99921600, Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

“ХӨВСГӨЛ АЗЗА” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Б.ГАЛБАДРАХ ТАНАА

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хөвсгөл АЗЗА” ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд аудит хийлээ.

“Хөвсгөл АЗЗА” ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд тус байгууллагын биет бус хөрөнгийн дансанд 1,200.0 мянган төгрөгийн газар эзэмших эрх, үндсэн хөрөнгийн дансанд 800.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж нэмэгдсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитаар 20,337.7 мянган төгрөгийн 6 зөрчил[1] илэрснээс 1,065.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,178.1 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, зардал, цалин, бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой 18,094.6 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж хүргүүлж байна.

**Бусад асуудлын хэсэг**

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Тус компанийн гүйцэтгэх захирал 2023 оны бизнес төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулан,  хэрэгжүүлэн ажилласан байна.

**Удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь  санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Мөрийн дугаар | Балансын зүйл | Үлдэгдэл | |
|---|---|---|---|
| | | 1 сарын 1 | 12 сарын 31 |
| 1.1.01 | Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 5,988,796.94 | 1,156,318.73 |
| 1.1.02 | Дансны авлага | 432,539,249.80 | 188,852,531.83 |
| 1.1.03 | Татвар, НДШ-ийн авлага | 19,466,381.88 | 22,133,306.26 |
| 1.1.04 | Бусад авлага | 51,935,214.46 | 32,008,214.46 |
| 1.1.06 | Бараа материал | 266,037,947.95 | 190,134,473.00 |
| **1.1.11** | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **777,471,065.51** | **434,284,844.28** |
| 1.2.01 | Үндсэн хөрөнгө | 833,730,126.75 | 677,690,409.57 |
| 1.2.06 | Хойшлогдсон татварын хөрөнгө | 1,503,474.48 | 8,932,753.07 |
| 1.2.09 | Газар / Биет бус хөрөнгө - Бусад / | 206,804,600.00 | 208,004,600.00 |
| **1.2.10** | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **1,040,534,726.75** | **894,087,762.64** |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,818,005,792.26** | **1,328,372,606.92** |
| 2.1.1.01 | Дансны өглөг | 145,109,154.98 | 151,994,105.60 |
| 2.1.1.02 | Цалингийн өглөг | 0.00 | 7,920,000.00 |
| 2.1.1.03 | Татварын өр | 126,103,896.02 | 159,345,029.77 |
| 2.1.1.04 | НДШ - ийн өглөг | 52,536,530.99 | 126,103,699.87 |
| **2.1.1.13** | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **323,749,581.99** | **445,362,835.24** |
| 2.1.2.01 | Урт хугацаат зээл | 448,747,239.00 | 448,747,239.00 |
| **2.1.2.06** | **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **448,747,239.00** | **448,747,239.00** |
| **2.2** | **Өр төлбөрийн нийт дүн** | **772,496,820.99** | **894,110,074.24** |
| 2.3.01 | Өмч: - төрийн | 669,879,751.09 | 669,879,751.09 |
| 2.3.06 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 33,609,027.31 | 33,609,027.31 |
| 2.3.08 | Эздийн өмчийн бусад хэсэг | 377,935,071.00 | 379,135,071.00 |
| **2.3.09** | **Хуримтлагдсан ашиг** | **-35,914,878.13** | **-647,821,316.72** |
| 2.3.09.1 | Тайлангийн үеийн ашиг | 61,045,212.16 | -611,906,438.59 |
| 2.3.09.2 | Өмнөх үеийн ашиг | -96,960,090.29 | -35,914,878.13 |
| **2.3.11** | **Эздийн өмчийн дүн** | **1,045,508,971.27** | **434,802,532.68** |
| **2.4** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **1,818,005,792.26** | **1,328,912,606.92** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Мөрийн дугаар | Балансын зүйл | Өмнөх оны дүн | Тайлант жилийн дүн |
|---|---|---|---|
| **01** | **Борлуулалтын орлого (цэвэр)** | **1,832,258,301.82** | **1,471,744,201.46** |
| **02** | **Борлуулалтын өртөг** | **1,526,176,607.50** | **1,810,569,637.70** |
| **03** | **Нийт ашиг( алдагдал)** | **306,081,694.32** | **-338,825,436.24** |
| 08 | Бусад орлого | 873,972.72 | 0.00 |
| 8.1 | Орлогын дүн | 873,972.72 | 0.00 |
| **10** | **Ерөнхий ба удирдлагын зардал** | **239,127,653.52** | **253,154,002.35** |
| 12.1 | Зардлын дүн | 239,127,653.52 | 253,154,002.35 |
| | Бусад ашиг алдагдал | | -19,927,000.00 |
| **18** | **Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)** | **67,828,013.52** | **-611,906,438.59** |
| 19 | Орлогын татварын зардал | 6,782,801.36 | 0.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **20** | **Татварын дараах ашиг (алдагдал)** | **61,045,212.16** | **-611,906,438.59** |
| **22** | **Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)** | **61,045,212.16** | **-611,906,438.59** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **1,655,941,884.50** | **1,746,148,520.23** |
| **1.1.1** | **Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого** | **1,640,447,882.20** | **1,744,436,512.00** |
| 1.1.2 | Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | 35,000.00 | 0.00 |
| 1.1.3 | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 134,002.30 | 155,259.00 |
| 1.1.6 | Бусад мөнгөн орлого | 15,325,000.00 | 1,556,749.23 |
| **1.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **1,696,660,003.23** | **1,846,328,380.37** |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 529,931,619.93 | 571,325,113.06 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 67,633,856.68 | 81,403,173.45 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 409,561,383.49 | 377,478,960.00 |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн | 77,054,029.69 | 231,864,764.54 |
| 1.2.5 | Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн | 521,075,234.00 | 397,741,618.55 |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 59,051,253.44 | 102,503,757.77 |
| 1.2.8 | Даатгалын төлбөрт төлсөн | 3,808,526.00 | 2,508,373.00 |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | 28,544,100.00 | 81,502,620.00 |
| **1.3** | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **-40,718,118.73** | **-100,179,860.14** |
| **2** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | **0.00** | **0.00** |
| **2.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **106,072,929.00** | **100,749,893.08** |
| 2.1.5 | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | 106,072,929.00 | 99,510,893.08 |
| 2.1.8 | Бусад | 0.00 | 1,239,000.00 |
| **2.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **58,825,000.00** | **17,042,613.00** |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 58,025,000.00 | 880,000.00 |
| 2.2.5 | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | 800,000.00 | 16,162,613.00 |
| **2.3** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **47,247,929.00** | **83,707,280.08** |
| **3** | **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | **0.00** | **0.00** |
| **3.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **39,957,000.00** | **214,070,000.00** |
| 3.1.1 | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 39,957,000.00 | 214,070,000.00 |
| **3.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **43,323,870.00** | **202,429,898.15** |
| 3.2.1 | Зээл,өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 40,523,870.00 | 202,429,898.15 |
| 3.2.4 | Төлсөн ногдол ашиг | 2,800,000.00 | 0.00 |
| **3.3** | **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **-3,366,870.00** | **11,640,101.85** |
| **4** | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **3,162,940.27** | **-4,832,478.21** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **2,825,856.67** | **5,988,796.94** |
| **6** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **5,988,796.94** | **1,156,318.73** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Үзүүлэлт | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **2021 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл** | **669,879,751.09** | **33,609,027.31** | **377,935,071.00** | **-95,496,690.04** | **985,927,159.36** |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 0.00 | 0.00 | 0.00 | 61,045,212.16 | 61,045,212.16 |
| Зарласан ногдол ашиг | 0.00 | 0.00 | 0.00 | -1,463,400.25 | -1,463,400.25 |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | **0.00** |
| **2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл** | **669,879,751.09** | **33,609,027.31** | **377,935,071.00** | **-35,914,878.13** | **1,045,508,971.27** |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 0.00 | 0.00 | 0.00 | -611,906,438.59 | -611,906,438.59 |
| Өмчид гарсан өөрчлөлт | 0.00 | 0.00 | 1,200,000.00 | 0.00 | 1,200,000.00 |
| **2023 оны 12 сарын 31-р үлдэгдэл** | **669,879,751.09** | **33,609,027.31** | **379,135,071.00** | **-647,821,316.72** | **434,802,532.68** |

## 2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

| | Үзүүлэлт | 2023 | | Харьцуулалт | |
|---|---|---|---|---|---|
| | | төлөвлөгөө | гүйцэтгэл | 2023 гүйц/ 2023 төл | зөрүү /2023 гүйц-2022 төл |
| 1 | **Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт** | **2,051,143.900** | **1,471,744,201.46** | 71.8 | (579,399.7) |
| | а/ Улсын чанартай зам засвар арчлалт | 1,363,636.300 | 999,787,598.18 | 73.3 | (363,848.7) |
| | б/Орон нутгийн чанартай зам засварын ажил | 686,007.600 | 467,680,406.36 | 68.2 | (218,327.2) |
| | в/ Бусад орлого | 1,500.000 | 4,276,196.92 | 285.1 | 2,776.2 |
| 2 | **НИЙТ ОРЛОГО** | **2,051,143.900** | **1,471,744,201.46** | 71.8 | (579,399.7) |
| 3 | **НИЙТ ЗАРДАЛ** | **2,039,950.100** | **2,039,950,100.00** | 102.1 | 43,693.9 |
| | Үүнээс: Удирдлагын зардал | 302,252.300 | 253,154,002.35 | 83.8 | (49,098.3) |
| 4 | Татварын өмнөх ашиг | 11,193.800 | -611,906,438.59 | (5,466.4) | (623,093.6) |
| 5 | Цэвэр ашиг /алдагдал/ | 10,074.400 | - | - | (10,074.4) |
| 6 | **Төсвийн төлбөрт нийт дүн** | **230,412.900** | **198,604.100** | 86.2 | (31,808.8) |
| | Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар | 1,007.400 | - | - | (1,007.4) |
| | Нэмэгдсэн өртгийн албан татвар | 95,665.000 | 60,153.900 | 62.9 | (35,511.1) |
| | Ус ашигласны төлбөр | 311.000 | - | - | (311.0) |
| | Газрын төлбөр | 988.500 | 988.500 | 100.0 | - |
| | Агаарын бохирдлын төлбөр | 324.000 | 123.200 | 38.0 | (200.8) |
| | Тээврийн хэрэгслийн татвар | 1,636.000 | 837.900 | 51.2 | (798.1) |
| | ЭМНДШ | 82,092.000 | 87,566.100 | 106.7 | 5,474.1 |
| | Үл хөдлөхийн татвар | 1,800.000 | 1,800.000 | 100.0 | - |
| | ХАОАТ | 46,589.000 | 46,964.500 | 100.8 | 375.5 |
| | Бусад | - | 170.000 | | 170.0 |
| 7 | Төрийн өмчийн ноогдол ашигт | 32,054.000 | - | - | (32,054.0) |
| 8 | Нийт ажиллагсдын тоо | 37 | 34 | 91.9 | (3.0) |
| 9 | Нийт цалингийн сан | 683,328.000 | 575,035.600 | 84.2 | (108,292.4) |
| 10 | Нэг ажилтны дундаж цалин | 1,539.000 | 1,409.400 | 84.2 | (243.9) |
| 13 | Борлуулалтын 1 төг-т ноогдох зардал | 1,000 | 1.420 | 142.4 | 0.4 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 14 | Хөрөнгө оруулалт | 158,929.800 | 800.000 | 0.5 | (158,129.8) |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 20,337.7 мянган төгрөгийн 6 зөрчил[2] илэрснээс 1,065.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,178.1 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, зардал, цалин, бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой 18,094.6 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж хүргүүлж байна.

### 3.1Төлбөрийн акт

Шатахууны зарцуулалтыг шалгахын тулд жолоочийн тооцооны хуудсыг түүвэрлэн авч дахин тооцоход 1,065.0 мянган төгрөгийн шатахууныг илүү тооцон зарцуулсан байна. Энэ нь ЗТХС-ын 2019 оны 390 тушаалаар батлагдсан *"Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм*" -ыг зөрчсөн нь *"нийцсэн бөгөөд зохистой*" байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 3.2 Албан шаардлага

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингаас 1,178.1 мянган төгрөгийн ХХОАТ-ыг тооцон суутгаж гарт олгох мөнгийг дутуу олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 144.7 *"Хөгжлийн бэрхшээлтэй хүн тэтгэвэр, тэтгэмж авч байгаа нь түүний цалин хөлсийг бууруулах болон энэ хуульд заасан бусад эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй, мөн ХХОАТ-ын тухай хуулийн 22.1.2.-т "хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого"-ыг албан татвараас чөлөөлнө"* гэсэн заалтыг зөрчсөн ба "*нийцсэн бөгөөд зохистой*" байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

<u>*Илрүүлэлт:*</u> Барилга байгууламжийн дансанд 17,280.0 мянган төгрөгийн эзэмшил ашиглалтгүй, бусдын эзэмшилд буй хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30.2-д "*Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад хөдлөх хөрөнгийг Засгийн газрын шийдвэрээр, Засгийн газраас зөвшөөрөл олгосон тохиолдолд төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр шилжүүлж болно*" зөрчсөн нь эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

<u>*Өгсөн зөвлөмж*</u>: Үндсэн хөрөнгийг бүртгэлд үнэн зөв, бодитой тайлагнах

2. Цалингийн тооцоололтой холбоотой:

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*Илрүүлэлт:* Цалингийн хүснэгт болон нийгмийн даатгалын тайлантай тулгахад 2 ажилтны цалинг 219.6 мянган төгрөгийг дутуу, 1 хүний цалинг 595.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 102.1.5-д "*цалин хөлсийг тооцох аргачлал ил тод, ойлгомжтой байх*". "Нийгмийн даатгалын тухай" хуулийн 17.1.1-*т "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх"* гэсэн заалт зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>*Өгсөн зөвлөмж:*</u> Цалингийн тооцооллыг зөв хийх

3.Үндсэн хөрөнгийн данстай холбоотой

*Илрүүлэлт:* Үндсэн хөрөнгийн дансанд 53 нэр төрлийн 554,771.4 мянган төгрөгийн анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 271 дүгээр тогтоолын 7.1.-д "*Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт иргүүлж шийдвэрлүүлнэ*", гэсэн заалтыг зөрчсөн ба үнэлгээ ба хувиарлалт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>*Өгсөн зөвлөмж:*</u> УСНББОУС 17 дагуу үндсэн хөрөнгийг 3-5 жил тутумд дахин үнэлгээ хийлгэх буюу актлаж устгах шийдвэрийг гаргуулж байх.

4.Зардлын данстай холбоотой

*Илрүүлэлт:* Тайлангийн хугацаанд орлого дутуу төвлөрүүлж, зардлыг хэтрүүлэн зарцуулж 611,898.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.2-д "*батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах*"; 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэсэн заалтыг зөрчсөн ба "*нийцсэн бөгөөд зохистой"* байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>*Өгсөн зөвлөмж:*</u> Төлөвлөгөөний дагуу орлогыг бүрэн төвлөрүүлж зорилтод түвшинд хүрч ажиллах.

1. Шилэн данстай холбоотой

*Илрүүлэлт:* Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 145 мэдээлэл байршуулахаас 119 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 15 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "*мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх*", 4.1.3-т *"тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх",* заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байгаа нь *"нийцсэн бөгөөд зохистой*" байх батламж мэдэгдлийг хангаж ажиллаагүй байна.

<u>*Өгсөн зөвлөмж*</u>: Шилэн дансны мэдээллийг хугацаанд бүрэн мэдээлж байх.

2. Биет бус хөрөнгөтэй холбоотой

*Илрүүлэлт:* Компанийн эзэмшлийн газар эзэмших эрхийн талбайн хэмжээ зөрүүтэй, газрыг зориулалт, бүсчлэлийн дагуу үнэлээгүй 13756 м.кв талбай бүхий газар эзэмших эрхийн үнэлгээ 65.330.0 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна.Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71.1.1-д “*үндсэн хөрөнгөд гарсан хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан байх, техник, технологийн баримт бичгийг гүйцэд бүрдүүлсэн байх*”, Засгийн газрын 2018 оны 182-р тогтоолын 4 дүгээр хавсралтын "*Хот, тосгон, бусад суурины 1 га газрын суурь үнэлгээ"-г* хэрэгжүүлж ажиллаагүй нь “*нийцсэн бөгөөд зохистой*” байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>* Биет бус хөрөнгийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн үнэн зөв тайлагнах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үндсэн хөрөнгийн дансанд эзэмшил, ашиглалтанд байхгүй хөрөнгө байна. | 1 | 17,280.0 | | | | | 1 | 17,280.0 |
| Цалингийн тооцоолол зөрүүтэй байсан | 1 | 814.6 | | | | | 1 | 814.6 |
| Цалингийн тооцооллын алдаа | 1 | 1,178.1 | | | 1 | 1,178,1 | | |
| Шатахууны норм хэтрүүлсэн | 1 | 1,065.0 | 1 | 1,065.0 | | | | |
| Тэг үлдэгдэлтэй үндсэн хөрөнгө | 1 | 00.0 | | | | | 1 | 00.0 |
| Төлөвлөгөө гүйцэтгэлийн хэтрэлт | 1 | 00.0 | | | | | 1 | 00.0 |
| **Дүн** | **6** | **20,337.7** | **1** | **1,065.0** | **1** | **1,178.1** | **4** | **18,094.6** |

**Нийцлийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Мэдээлэл хугацаа хоцроосон | 1 | | | | | | 1 | - | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

**5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | НИЙТ | 1 | 1 | | | 1 | | | |